

БАТЛАВ:

“Монгол Улсын
Хөгжлийн Банк” ХХК-
ийн Гүйцэтгэх захирал:



БАТЛАВ:

“Ди Би Эм лизинг”
ХХК-ийн
Гүйцэтгэх захирал:



БАТЛАВ:

“Амгалан дулааны
станц” ТӨХК-ийн
Гүйцэтгэх захирал:



БАТЛАВ:

“Улаанбаатар
дулааны сүлжээ”
ТӨХК-ийн
Гүйцэтгэх захирал:



ТӨЛБӨР ТООЦООНЫ ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

2022 оны 12-р сарын 09-ний өдөр

№: ХАГ-22/02

Улаанбаатар хот

2023 оны 2 сарын 01.

2023/09

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү Төлбөр тооцооны хамтран ажиллах гэрээ (цаашид “Гэрээ” гэх)-г дараах талууд харилцан тохиролцож байгуулав:

1.1.1. Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Энхтайваны өргөн чөлөө, 19 байр, 11, 12 дугаар давхар хаягт байрлах, улсын бүртгэлийн 9016001019, регистрийн 5461626 дугаартай “Монгол Улсын Хөгжлийн Банк” ХХК (цаашид “МУХБ” гэх) түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал Н.Мандуул;

1.1.2. Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энхтайваны өргөн чөлөө, 19 байр, 12 дугаар давхар хаягт байрлах, Монгол Улсын Хөгжлийн банкны охин Компани болох улсын бүртгэлийн 9011680088 дугаартай, регистрийн 6196233 дугаартай, “Ди Би Эм лизинг” ХХК (цаашид “Түрээслүүлэгч” гэх) түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал Н.Цэрэнсодном,

1.1.3. Монгол Улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 8-р хороо, УС-15, 1-0 тоот хаягт байрлах, улсын бүртгэлийн 9012001030, регистрийн 6021646 дугаартай “Амгалан дулааны станц” ТӨХК (цаашид “Түрээслэгч” гэх) түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал М.Мөнхөө;

1.1.4. Монгол Улс, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 3-р хороо, Ф.Энгельсийн гудамж-18 хаягт байрлах, улсын бүртгэлийн 9012001011, регистрийн 2688476 дугаартай “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК (цаашид “УБДС” гэх) түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал Г.Баярсайхан, (цаашид хамтад нь “Талууд” гэх).

1.2. Гэрээг Монгол Улсын Иргэний хууль, Эрчим хүчний тухай хууль, Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль, Санхүүгийн түрээс /лизинг/-ийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг үндэслэн, дараах нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

1.3. Гэрээний зорилго нь МУХБ нь Санхүүгийн түрээсийн гэрээний дагуу төлөх төлбөрийг Түрээслэгчийн данснаас Түрээслүүлэгчийн дансанд эргэн төлөлтийн хуваарьт хугацааны дагуу түргэн шуурхай шилжүүлэг хийх буюу төлбөр тооцоо гүйцэтгэх, УБДС нь МУХБ дахь Түрээслэгчийн дансанд холбогдох тарифын дагуу тогтоосон дулааны төлбөрийг тогтмол шилжүүлэхтэй холбоотой Талуудын хооронд үүссэн эрх зүйн харилцааг зохицуулах, түүний эрх, үүрэг, хариуцлагын хэм хэмжээг тогтооход оршино.

1.4. Гэрээ нь Түрээслүүлэгч болон Түрээслэгчийн хооронд байгуулсан “Санхүүгийн түрээсийн гэрээ”-нд заасан нөхцөлийн дагуу үндсэн төлбөр, хүүгийн төлбөр бүрэн төлж барагдуулах болон бусад холбогдох үүргийн гүйцэтгэл бүрэн хангагдах хүртэл хугацаанд хүчинтэй байна.

1.5. Гэрээнд тусгайлан заагаагүй эрх зүйн бусад харилцаа нь Санхүүгийн түрээсийн гэрээ, Төсөл хэрэгжүүлэх гэрээ болон бусад холбогдох хууль тогтоомж, гэрээгээр зохицуулагдана.

Хоёр.Нэр томьёоны тайлбар

2.1. Энэхүү Гэрээнд холбогдох эрх зүйн баримт бичгийг дараах нэр томьёогоор тодорхойлж, тайлбарлана. Үүнд:

2.1.1. “Төсөл” гэж: Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаартай тогтоолоор баталсан Шинэ сэргэлтийн бодлогын 2 дугаар хавсралтын “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2 дугаар зүйлийн 2.1.3-т заасан үйл ажиллагааны дагуу “Амгалангийн дулааны станцыг өргөтгөн Улаанбаатар хотын зүү бүсийн дулааны хэрэглээний өсөлтийг хангах”-аар Түрээслэгчийн хүчин чадлыг 116Мв (100Гкал/цаг)-аар нэмэгдүүлэх ажлыг;

2.1.2. “Тариф” гэж: Түрээслэгчийн Гэрээний эргэн төлөлтийг хангахад баталгаа болгон ЭХЗХ-ны 2022 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 444 дугаартай тогтоолоор баталсан “Амгалан дулааны станц ТӨХК-ийн худалдах дулааны тариф”-ыг;

2.1.3. “Чадлын тариф” гэж: ЭХЗХ-ны 2022 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 444 дугаартай тогтоолоор баталсан “Амгалан дулааны станц ТӨХК-ийн сар бүр тогтмол худалдах дулааны тариф”-ыг;

2.1.4. “Энергийн тариф” гэж: ЭХЗХ-ны 2022 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 444 дугаартай тогтоолоор баталсан “Амгалан дулааны станц ТӨХК-ийн үйлдвэрлэсэн дулаан худалдах тариф”-ыг;

2.1.5. “Дулааны төлбөр” гэж: Гэрээний 2.1.3 болон 2.1.4-т заасан тарифын дагуу “УБДС”-иас Түрээслэгчид шилжүүлэх төлбөрийг;

2.1.6. “Дулаан нийлүүлэх гэрээ” гэж: Тариф, Горимын дагуу Түрээслэгч болон УБДС-н хооронд 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдөр байгуулсан 120/2022 дугаартай “Дулааны эрчим хүч худалдах, худалдан авах гэрээ”-г;

2.1.7. “Төсөл хэрэгжүүлэх гэрээ” гэж: Төслийг хэрэгжүүлэх зорилгоор Эрчим хүчний яам, ЭХЗХ болон Түрээслүүлэгчийн хооронд 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдөр байгуулсан ХАГ-22/01 дугаартай хамтран ажиллах гэрээг;

2.1.8. “Санхүүгийн түрээсийн гэрээ” гэж: “Ди Би Эм лизинг” ХХК болон “Амгалан дулааны станц” ТӨХК, “Эрчим хүчний зохицуулах хороо”, “Диспетчерийн үндэсний төв” ТӨХХК, “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-ийн хооронд 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдөр байгуулсан СТГ-22/01 дугаартай гэрээг;

2.1.9. “ЭХЗХ” гэж: Эрчим хүчний зохицуулах хороог;

2.1.10. “ДҮТ” гэж: “Диспетчерийн үндэсний төв” ТӨХХК-г;

2.1.11. “Горим” гэж: ДҮТ-өөс боловсруулж Эрчим хүчний дэд сайдаар батлуулсан “Улаанбаатар хотын дулаан хангамжийн 2022-2027 онуудын өвлийн их ачааллын горим”-ыг;

2.1.12. “Бусад орлого” гэж: Түрээслэгчийн үндсэн үйл ажиллагаанаас бусад хэлбэрээр олсон бүхий л орлогыг;

2.1.13. “Түрээслүүлэгчийн данс” гэж: “Ди Би Эм лизинг” ХХК-ийн зөвхөн МУХБ дахь 3600005414 тоот төгрөгийн харилцах дансыг;

2.1.14. “Түрээслэгчийн данс” гэж: “Амгалан дулааны станц” ТӨХК-ийн зөвхөн МУХБ дахь 3600001547 тоот төгрөгийн харилцах дансыг.

2.1.15. “Түрээсийн зүйл” гэж: Яам, Түрээслэгч болон түүний сонгосон ажил гүйцэтгэгч, Түрээслүүлэгчийн хооронд байгуулсан Түрээсийн зүйлийг нийлүүлэх гэрээнд



заасан ашиглалтын явцад үндсэн шинж чанараа алддаггүй биет эд хөрөнгө болох QXF116-1.6/130/70 маркийн дулааны эрчим хүч үйлдвэрлэх 1 ширхэг зуух, 4 ширхэг үнс хадгалах сав болон түүнд холбогдох бусад иж бүрдэл тоноглол, тоног төхөөрөмжийг хэлнэ;

Гурав.УБДС-н эрх, үүрэг

3.1. УБДС нь Гэрээгээр дараах арга, хэмжээг авч хэрэгжүүлэхээр үүрэг хүлээв. Үүнд:

3.1.1. Дулаан нийлүүлэх гэрээний дагуу дулааны борлуулалтын орлогыг бүрэн цуглуулж, Дулааны төлбөрийг Түрээслэгчид Дулаан нийлүүлэх гэрээнд заасан хугацаанд Түрээслэгчийн дансанд бүрэн шилжүүлэх, Түрээслэгчид шилжүүлэх Дулааны төлбөрийг хойшлуулахгүй байх;

3.1.2. Түрээслэгчийн болон өөрийн үйл ажиллагаанд холбогдох бүхий л мэдээллийг МУХБ болон Түрээслүүлэгчээс шаардсаны дагуу гаргаж өгөх;

3.1.3. Дулааны төлбөрийг Санхүүгийн түрээсийн гэрээний эргэн төлөлт бүрэн төлөгдөж дуусах хүртэл хугацаанд саадгүй, шуурхай байдлаар Түрээслэгчийн дансанд шилжүүлэх;

3.1.4. Дулааны төлбөрийг энэхүү Гэрээнд зааснаас өөр бусад банкны дансанд шилжүүлэхгүй байх;

3.1.5. Түрээслэгчийн Санхүүгийн түрээсийн гэрээний үндсэн төлбөр, хүүгийн төлбөр болон алдангийг төлөх чадварт нь нөлөөлөх эрсдэл үүссэн, эсхүл үүсэх нөхцөл байдал бий болсон гэж үзсэн тохиолдолд уг асуудлыг МУХБ болон Түрээслүүлэгчид нэн даруй мэдэгдэх;

3.1.6. УБДС нь энэхүү Гэрээ болон холбогдох бусад гэрээ, хууль тогтоомжид заасан үүргээ биелүүлээгүй үйлдэл, эс үйлдэхүй гаргаснаар Түрээслэгч нь Санхүүгийн түрээсийн гэрээнд заасан төлбөрийг хуваарийн дагуу төлөх боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд Түрээслэгчийн хүлээх алданги, Түрээслүүлэгч болон Түрээслэгчид учирсан хохирлыг тус тус хариуцаж, бүрэн төлж барагдуулах;


3.1.7. ЭХЗХ-оос баталсан Тариф, ДҮТ-өөс батлуулсан Горимыг Санхүүгийн түрээсийн гэрээнд заасан нөхцөлийн дагуу шинэчлэн баталсан, нэмэлт, өөрчлөлт оруулсан тохиолдолд тухайн тариф, горимын дагуу Дулаан нийлүүлэх гэрээг ажлын 5 өдрийн дотор шинэчлэн байгуулах, нэмэлт, өөрчлөлт оруулж, холбогдох гэрээг Түрээслүүлэгчид нэн даруй хүргүүлэх;

3.1.8. УБДС нь Дулаан нийлүүлэх гэрээг Санхүүгийн түрээсийн гэрээнд зааснаас бусад нөхцөлөөр шинэчлэн байгуулсан, нэмэлт өөрчлөлт оруулсан, цуцалсан, татгалзсан, дуусгавар болгосон, хүчингүйд тооцсоноор Түрээслэгч нь Санхүүгийн түрээсийн гэрээний төлбөрийн үүргээ биелүүлэх боломжгүй нөхцөлд хүрсэн тохиолдолд Түрээслэгчийн төлөх алданги, Түрээслүүлэгч болон Түрээслэгчид учирсан хохирлыг тус тус хариуцаж, бүрэн төлж барагдуулах;

3.1.9. Түрээслэгчийн дансанд Санхүүгийн түрээсийн гэрээний эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлөх төлбөртэй тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг эргэн төлөлт хийх өдрөөс ажлын 5 хоногийн өмнө тогтмол байршуулах;

3.1.10. Чадлын тарифын төлбөрийг ямар ч нөхцөл байдал үүссэн Түрээслэгчийн дансанд тогтмол шилжүүлэх;

3.1.11. Энэхүү Гэрээ, Санхүүгийн түрээсийн гэрээ, Дулаан нийлүүлэх гэрээ болон бусад холбогдох хууль тогтоомж, шийдвэрт заасан үүргээ биелүүлээгүй үйлдэл, эс үйлдэхүйн улмаас Түрээслэгч нь Санхүүгийн түрээсийн гэрээний эргэн төлөлтийн зөрчил гаргасан тохиолдолд Түрээслэгчийн төлөх алдангийн төлбөр болон Түрээслүүлэгч, Түрээслэгчид учирсан хохирлыг хариуцаж, бүрэн төлж барагдуулах;



3.1.12. Дулааны төлбөрийг банк хоорондын гүйлгээ хаах цагаас өмнө буюу 15 цагаас өмнө шилжүүлэх;

3.1.13. Эргэн төлөлтийн хуваарьт төлбөрийн өдөр нь амралтын болон нийтээр амрах баярын өдөр байвал түүний өмнөх ажлын өдөр төлбөрийн гүйлгээг хийх;

3.1.14. Санхүүгийн түрээсийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулах зорилгоор Дулааны төлбөрийг бусад эрчим хүчний үйлдвэрлэлийн тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагаас онцгойлж, тэргүүн ээлжид Түрээслэгчийн дансанд шилжүүлэх;

3.1.15. Холбогдох бусад хууль тогтоомж болон гэрээнд заасан үүрэг.

3.2. УБДС нь дараах эрхтэй. Үүнд:

3.2.1. Дулааны төлбөр шилжүүлсэнтэй холбоотой дансны хуулга, төлбөр тооцооны мэдээллийг МУХБ-наас гаргуулж авах;

3.2.2. Дулаан нийлүүлэх гэрээг энэхүү Гэрээ болон Санхүүгийн түрээсийн гэрээнд зааснаар шинэчлэн байгуулах, нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд Түрээслэгч талаа гэрээ байгуулахтай холбоотой мэдээлэл, баримт бичгийг шаардах, гаргуулж авах;

3.2.3. Санхүүгийн түрээсийн гэрээний дагуу тухайн сард төлөх төлбөрийн мэдээллийг Түрээслэгчээс шаардаж, гаргуулж авах.

Дөрөв.МУХБ-ны эрх, үүрэг

4.1. МУХБ нь Гэрээгээр дараах арга, хэмжээг авч хэрэгжүүлэхээр үүрэг хүлээв. Үүнд:

4.1.1. Талуудын хоорондох төлбөр тооцоог түргэн, шуурхай гүйцэтгэх;

4.1.2. Түрээслүүлэгчээс ирүүлсэн Санхүүгийн түрээсийн гэрээний эргэн төлөлтийн хуваарь болон төлбөрийн шилжүүлэг хийх мэдэгдэл (цахим шуудан)-ийн дагуу Түрээслэгчийн данснаас Түрээслүүлэгчийн дансанд Санхүүгийн түрээсийн гэрээний үндсэн төлбөр, хүүгийн төлбөрийг үл маргах журмаар, төлбөр төлөх өдрөөр шууд шилжүүлэг хийх;

4.1.3. Түрээслүүлэгчээс ирүүлсэн нэхэмжлэлийн дагуу алданги, даатгалын хураамжийн төлбөрийг Түрээслэгчийн данснаас Түрээслүүлэгчийн дансанд үл маргах журмаар шууд шилжүүлэг хийх;


4.1.4. Санхүүгийн түрээсийн гэрээний эргэн төлөлтийн хуваарьт хугацаа амралтын болон нийтээр амрах баярын өдөр таарсан тохиолдолд өмнөх ажлын өдөр шилжүүлгийг хийх;

4.1.5. Санхүүгийн түрээсийн гэрээний эргэн төлөлтийн хуваарийн дагуу шилжүүлэг хийж, төлбөр тооцоо гүйцэтгэхдээ даатгалын хураамж, алданги, хүү, үндсэн төлбөр гэсэн дарааллаар тооцож шилжүүлэг хийх ба даатгалын хураамж, алдангийн төлбөрийг зөвхөн Түрээслүүлэгчээс ирүүлэх нэхэмжлэлийг үндэслэн шилжүүлгийг хийж, төлбөр тооцоог гүйцэтгэнэ;

4.1.6. Түрээслүүлэгчээс ирүүлсэн албан шаардлагын дагуу Түрээслэгчийн дансыг битүүмжлэх, уг дансанд байршиж буй мөнгөн хөрөнгөөс Санхүүгийн түрээсийн гэрээний эргэн төлөлтийг хангуулах зорилгоор Түрээслүүлэгчийн дансанд үл маргах журмаар шууд шилжүүлэг хийх, төлбөр тооцоог гүйцэтгэх;

4.1.7. Санхүүгийн түрээсийн гэрээг цуцалсан тохиолдолд Түрээслүүлэгчээс ирүүлсэн албан шаардлагын дагуу Түрээслэгчийн дансны орлого болон үлдэгдлийг Түрээслүүлэгчийн дансанд үл маргах журмаар шилжүүлэх, төлбөр тооцоог гүйцэтгэх;

4.1.8. Талуудын төлбөр тооцоо гүйцэтгүүлсэнтэй холбогдох дансны хуулга, төлбөрийн мэдээллийг Талуудаас шаардсан хугацаанд гаргаж өгөх;



ДИ БИ ЭМ ЛИЗИНГ ХХК



4.1.9. Түрээслэгчийн дансны үлдэгдэл Санхүүгийн түрээсийн гэрээний Хавсралт 2-т заасан эргэн төлөлтийн хуваарьт хугацааны дагуу төлбөр төлөхөд хүрэлцэх тохиолдолд энэхүү Гэрээнд заасан төлбөр тооцоо гүйцэтгэх үүргээ Санхүүгийн түрээсийн гэрээний эргэн төлөлтийн хуваарьт заасан хугацаанд болон/эсхүл Түрээслүүлэгчээс ирүүлсэн нэхэмжлэлийн дагуу гүйцэтгээгүйн улмаас Түрээслүүлэгчид учирсан хохирлыг бүрэн хариуцаж, барагдуулах;

4.1.10. Түрээслэгчийн дансны үлдэгдэл Санхүүгийн түрээсийн гэрээний Хавсралт 2-т заасан эргэн төлөлтийн хуваарьт хугацааны дагуу төлбөр төлөхөд хүрэлцэхгүй тохиолдолд дансны үлдэгдлийг шууд Түрээслүүлэгчийн дансанд шилжүүлэх;

4.1.11. Холбогдох хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

4.2. МУХБ нь дараах эрхтэй. Үүнд:

4.2.1. Түрээслэгчийн үйл ажиллагаанд холбогдох шаардлагатай мэдээллүүдийг Талуудаас шаардах, гаргуулан авах;

4.2.2. Санхүүгийн түрээсийн гэрээний эргэн төлөлтийн хуваарийг Түрээслүүлэгч болон Түрээслэгчээс гаргуулж авах;

4.2.3. Харилцах дансны, төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой харилцагчийн мэдээлэл, баримт бичгийг Талуудаас шаардах, гаргуулж авах;

4.2.4. Түрээслэгчийн харилцах данснаас баталгаат гарын үсэг, тамга тэмдэг бүхий төлбөрийн даалгаврыг үндэслэн, Гэрээнд заасны дагуу шилжүүлэг хийх;

4.2.5. Түрээслэгчийн данс үлдэгдэлгүй байх тохиолдолд төлбөр тооцоо, шилжүүлэг хийхгүй байх.

Тав. Түрээслүүлэгчийн эрх, үүрэг

5.1. Түрээслүүлэгч нь Гэрээгээр дараах арга, хэмжээг авч хэрэгжүүлэхээр үүрэг хүлээв. Үүнд:

5.1.1. Санхүүгийн түрээсийн гэрээний эргэн төлөлтийн хуваарийг МУХБ-нд хүргүүлэх, тус хуваарьт өөрчлөлт орсон тохиолдолд өөрчлөгдсөн хуваарийг тухай бүр МУХБ-нд хүргүүлэх;

5.1.2. Санхүүгийн түрээсийн гэрээний эргэн төлөлтийн хуваарийн дагуу Санхүүгийн түрээсийн гэрээний үндсэн төлбөр, хүүгийн төлбөрийн шилжүүлэг хийх мэдэгдлийг тухай бүр МУХБ-нд хүргүүлэх;

5.1.3. Алданги, даатгалын хураамжийн төлбөрийг Түрээслэгчийн данснаас Түрээслүүлэгчийн дансанд үл маргах журмаар шилжүүлэг хийх нэхэмжлэлийг тухай бүр МУХБ-нд хүргүүлэх;

5.1.4. МУХБ-аас төлбөр тооцоо гүйцэтгэхтэй холбоотой шаардсан баримт бичиг, мэдээллийг гаргаж өгөх.

5.2. Түрээслүүлэгч нь дараах эрхтэй. Үүнд:

5.2.1. Дулааны төлбөрийг Санхүүгийн түрээсийн гэрээний төлбөрийн үүрэг бүрэн хангагдах хүртэлх хугацаанд Горим, Тариф, Дулаан нийлүүлэх гэрээний дагуу, саадгүй, шуурхай байдлаар Түрээслэгчийн дансанд шилжүүлэхийг УБДС-аас шаардах;

5.2.2. Санхүүгийн түрээсийн гэрээний эргэн төлөлтийн хуваарьт хугацаа болохоос өмнө чадлын тарифаар тогтоосон дулааны төлбөрийг сар бүр, тогтмол шилжүүлэх, Энергийн тарифаар тогтоосон дулааны төлбөрийг үйлдвэрлэж нийлүүлсэн дулааны

хэмжээгээр тухай бүр шилжүүлж, Түрээслэгчийн эргэн төлөлтийг хангуулахыг УБДС-аас шаардах;

5.2.3. Санхүүгийн түрээсийн гэрээний эргэн төлөлтийн хуваарийн дагуу тэргүүн ээлжид Түрээслэгчийн данснаас Түрээслүүлэгчийн дансанд сар бүр, тогтмол шилжүүлэг хийх, төлбөр тооцоо гүйцэтгэхийг МУХБ-аас шаардах;

5.2.4. Санхүүгийн түрээсийн гэрээний эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлөх төлбөртэй тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг Түрээслэгчийн дансанд эргэн төлөлт хийх өдрөөс ажлын 5 хоногийн өмнө тогтмол байршуулахыг УБДС болон Түрээслэгчээс шаардах;

5.2.5. Санхүүгийн түрээсийн гэрээний эргэн төлөлт хангагдахгүй байх эрсдэл үүссэн эсхүл төлбөрийн зөрчлөөс үүдэн тухайн сарын эргэн төлөлтийн дүнд алданги хуримтлагдсан бол Түрээслэгчийн дансыг битүүмжлэх, уг дансанд байршиж буй мөнгөн хөрөнгөөс төлбөрийг Түрээслүүлэгчийн дансанд үл маргах журмаар шууд шилжүүлэг хийх, төлбөр тооцоог гүйцэтгэх албан шаардлагыг МУХБ-нд хүргүүлэх;

5.2.6. МУХБ-аас өөрийн болон Түрээслэгчийн дансны хуулгыг гаргуулж авах;

5.2.7. Санхүүгийн түрээсийн гэрээний эргэн төлөлтийн зөрчил үүссэн тохиолдолд дансны орлогоос тэргүүн ээлжид зөрчлийг барагдуулахыг Түрээслэгчээс шаардах;

5.2.8. Түрээсийн зүйлийг ашигласан эсэхээс үл хамааран Санхүүгийн түрээсийн гэрээний эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлбөр төлөхийг Түрээслэгчээс шаардах;

5.2.9. Санхүүгийн түрээсийн гэрээний Хавсралт 2-т заасан эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлөх төлбөр болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийн зөрчлийг тэргүүн ээлжид барагдуулахыг Түрээслэгчээс шаардах;

5.2.10. Санхүүгийн түрээсийн гэрээг цуцалсан тохиолдолд Түрээслэгчийн дансны орлого болон үлдэгдлийг Түрээслүүлэгчийн дансанд үл маргах журмаар шилжүүлэх албан шаардлагыг МУХБ-нд хүргүүлэх;

5.2.11. Холбогдох хууль тогтоомж, гэрээнд заасан бусад эрх.

Зургаа.Түрээслэгчийн эрх, үүрэг

6.1. Түрээслэгч нь Гэрээгээр дараах арга, хэмжээг авч хэрэгжүүлэхээр үүрэг хүлээв. Үүнд:

6.1.1. Талуудын шаардсан мэдээлэл, баримт бичиг, Санхүүгийн түрээсийн эргэн төлөлтийн хуваарийг шаардсан хугацаанд гаргаж өгөх;

6.1.2. Өөрийн буюу Түрээслэгчийн дансанд Санхүүгийн түрээсийн гэрээний эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлөх төлбөртэй тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг эргэн төлөлт хийх өдрөөс ажлын 5 хоногийн өмнө тогтмол байршуулах;

6.1.3. УБДС нь энэхүү Гэрээ болон бусад холбогдох гэрээ, хууль тогтоомжид заасан үүргээ биелүүлэх боломжгүй нөхцөл тогтоогдсон, эсхүл уг асуудал үүссэн тохиолдолд Түрээслүүлэгчид нэн даруй мэдээллийг хүргүүлж, шаардлагатай арга хэмжээг шуурхай авах;

6.1.4. МУХБ нь Түрээслэгчийн төлбөрийн даалгаваргүй, нэхэмжлэлгүй, албан хүсэлтгүйгээр зөвхөн Санхүүгийн түрээсийн гэрээний эргэн төлөлтийн хуваарь болон Түрээслүүлэгчээс ирүүлсэн мэдэгдэл, нэхэмжлэл, албан шаардлагыг үндэслэн Түрээслэгчийн данснаас Түрээслүүлэгчийн дансанд үл маргах журмаар төлбөр шилжүүлэх, төлбөр тооцоо гүйцэтгэхийг Түрээслэгч нь бүрэн хүлээн зөвшөөрсөн бөгөөд Гэрээний

хугацаанд аливаа хэлбэрээр тус үйл ажиллагааг тасалдуулсан, зогсоосон үйлдэл, эс үйлдэхүй гаргахгүй байх;

6.1.5. Дулаан нийлүүлэх гэрээг энэхүү Гэрээ болон Санхүүгийн түрээсийн гэрээнд зааснаас бусад нөхцөлөөр шинэчлэн байгуулахгүй, нэмэлт өөрчлөлт оруулахгүй, цуцлахгүй, татгалзан гарахгүй, дуусгавар болгохгүй, хүчингүйд тооцуулахгүй байх;

6.1.6. ЭХЗХ-оос баталсан Тариф, ДҮТ-өөс батлуулсан Горимыг Санхүүгийн түрээсийн гэрээнд заасан нөхцөлийн дагуу шинэчлэн баталсан, нэмэлт, өөрчлөлт оруулсан тохиолдолд тухайн тариф, горимын дагуу Дулаан нийлүүлэх гэрээг ажлын 5 өдрийн дотор шинэчлэн байгуулах, нэмэлт, өөрчлөлт оруулах ба холбогдох гэрээг Түрээслүүлэгчид нэн даруй хүргүүлэх;

6.1.7. Дулааны төлбөрийг энэхүү Гэрээнд зааснаас бусад банкны дансанд шилжүүлэхийг УБДС-с шаардахгүй байх;

6.1.8. Түрээслэгчийн дансны үлдэгдэл Санхүүгийн түрээсийн гэрээний Хавсралт 2-т заасан эргэн төлөлтийн хуваарьт хугацааны дагуу төлбөр төлөхөд хүрэлцэхгүй тохиолдолд дансны үлдэгдлийг шууд Түрээслүүлэгчийн дансанд үл маргах журмаар шилжүүлэхийг МУХБ-д зөвшөөрөх;

6.1.9. Санхүүгийн түрээсийн гэрээг цуцалсан тохиолдолд Түрээслэгч нь өөрийн дансны орлого болон үлдэгдлийг Түрээслүүлэгчийн дансанд үл маргах журмаар шилжүүлэхийг МУХБ-д зөвшөөрөх;

6.1.10. Түрээслэгчийн бусад орлогоор Санхүүгийн түрээсийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулах, бусад орлогыг Түрээслэгчийн дансанд төвлөрүүлж байх Түрээслүүлэгчийн шаардлагыг хүлээн зөвшөөрөх, үл маргах;

6.1.11. холбогдох бусад хууль тогтоомж, гэрээнд заасан үүрэг.

6.2. Түрээслэгч нь дараах эрхтэй. Үүнд:

6.2.1. МУХБ-аас төлбөр тооцоо гүйцэтгүүлсэнтэй холбогдох мэдээлэл, баримт бичиг, дансны хуулгыг гаргуулж авах;

Долоо. Гэрээнээс татгалзах болон гэрээг дуусгавар болгох

7.1. Санхүүгийн түрээсийн гэрээний төлбөрийн үүрэг бүрэн хангагдсан тохиолдолд Гэрээ дуусгавар болно.

7.2. Талуудын аль нэг энэхүү Гэрээний үйл ажиллагааг хэрэгжүүлэх боломжгүй болсон нь хүндэтгэн үзэх шалтгаантай бол хугацаанаас өмнө Гэрээнээс татгалзаж болох ба үүний улмаас Талуудад учирсан хохирлыг Гэрээнээс татгалзсан тал бүрэн хариуцна.

7.3. Гэрээний 7.2-г зааснаар аль нэг тал гэрээнээс татгалзсанаар Гэрээ дуусгавар болсонд тооцно.

7.4. Түрээслүүлэгч нь дараах нөхцөл үүссэн тохиолдолд өөрийн санаачилгаар Гэрээг цуцлах эрхтэй. Үүнд:

7.4.1. Санхүүгийн түрээсийн гэрээ дуусгавар болсон;

7.4.2. УБДС, МУХБ болон Түрээслэгч нь Гэрээний үүргийг 2 ба түүнээс дээш удаа зөрчсөн;

7.4.3. УБДС, МУХБ болон Түрээслэгч нь Гэрээний үүргээ гурван удаа дараалан биелүүлээгүй;

7.4.4. УБДС, МУХБ болон Түрээслэгч нь Гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлээгүй эсхүл Түрээслүүлэгчийн тавьсан шаардлага, мэдэгдлийг хүргүүлснээс хойш тус мэдэгдэлд заасан хугацаа, түүнчлэн нэмэлтээр олгосон хугацаанд тус тус биелүүлээгүй;

7.4.5. УБДС, МУХБ болон Түрээслэгч нь төлбөр түргэн гүйцэтгэх болон төлбөрийн чадваргүй болсон, дампуурсан, бүтэц зохион байгуулалтад өөрчлөлт орсон, үйл ажиллагаагаа эрхлэх боломжгүй болсон эсхүл эдгээр нөхцөл байдал бий болох эрсдэл үүссэн байж болзошгүй тохиолдолд.

Найм. Бусад

8.1. Гэрээ нь Талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, хуулийн этгээдийн тэмдэг, тамга дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

8.2. Гэрээг 5 /тав/ эх хувь үйлдэнэ.

8.3. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах саналаа Талууд Санхүүгийн түрээсийн гэрээний эргэн төлөлтийн хуваарьт хугацаа болохоос ажлын 14 хоногийн өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Талууд урьдчилан нөгөө талдаа бичгээр мэдэгдэхгүйгээр, холбогдох зөвшөөрлийг авалгүйгээр энэхүү Гэрээнд заасан эрх, үүргээ бүхэлд нь эсхүл хэсэгчлэн бусдад шилжүүлэх, засварлах, өөрчлөхийг хориглох ба хэрэв зайлшгүй нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл Талуудын эрх бүхий төлөөлөгчид харилцан тохиролцож уг гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулна.

8.4. Талууд Гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй үйлдэл, эс үйлдэхүй гаргасан нь аль нэг талдаа бодит хохирол учруулсан бол тус хохирлыг барагдуулах үүрэг хүлээнэ.

8.5. Гэрээтэй холбогдон Талуудын хооронд үүсэх аливаа маргаантай асуудлыг Талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэх ба боломжгүй бол Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭГ ХЯНАСАН:

“Ди Би Эм лизинг” ХХК-ийн хуульч:

Д.Номин
ХУУЛЬЧ

/Д.Номин/

ТАЛУУДЫГ ТӨЛӨӨЛЖ ГЭРЭЭГ БАЙГУУЛСАН:

“Монгол Улсын Хөгжлийн Банк” ХХК-ийг төлөөлж Санхүүгийн газрын захирал:

Т.Баасанжав

“Монгол Улсын Хөгжлийн Банк” ХХК-ийн Төлбөр тооцооны хэлтсийн захирал:

Т.Наранцэцэг

“Ди Би Эм лизинг” ХХК-ийг төлөөлж Захиргааны үйл ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн:

Б.Энхтүшиг

“Ди Би Эм лизинг” ХХК-ийн Санхүүгийн түрээсийн үйл ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн:

Н.Бадрал

“Амгалан дулааны станц” ТӨХК-ийг төлөөлж Ерөнхий инженер:

Э.Мөнхжаргал

“Амгалан дулааны станц” ТӨХК-ийн СЭЗХ-ийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч:

Ө.Удвал

“Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-ийг төлөөлж Ерөнхий инженер:

Ш.Мөнхжаргал

“Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-ийн ЭЗСБХ-ийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч:

П.Оюунчимэг

